

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9.Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулах газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗУД БОЛОН ОЙ ХЭЭРИЙН
ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ОЛОН
НИЙТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ
ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Д.НЯМДОРЖ ТАНАА

2020.04.28 № 06/1397
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлж, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Д.Нямдорж Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн удирдлага санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 16-наас 2020 оны 4 дүгээр сарын 09-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төслийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ний ахлах аудитор А.Билгүүн, аудиторын туслах Ө.Батчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2020 оны 1 дугаар сарын 5-ны өдөр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрхэм зорилго:

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь гамшгийн эрсдэлийн удирдлагын үндэсний болон орон нутгийн байгууллага, багийн иргэдийн зуд болон ой хээрийн түймрийн эрсдэлийг удирдах чадавхыг бэхжүүлэхэд оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шадар сайдын багцад харьяалагдах Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багийн иргэдийн бүлгүүдийн орон нутагт суурилсан гамшгийн эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах.
- Гамшгийн бэлэн байдлыг сайжруулах жижиг хэмжээний дэд бүтэц, тоног төхөөрөмж, технологийн төслийг түршилтын журмаар хэрэгжүүлэх.
- Улс, аймаг, сумын төвшинд гамшгийн эрсдэлийг удирдах, хор уршгийг арилгах удирдлагын чадавхийг бэхжүүлэх.
- Дээрх 3 чиглэлд үйл ажиллагаа явуулж нийтдээ 13 цогц үр дүнд хүрэх байдлаар төслийн чиглэлээ тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны үр дүнгийн хураангуй:

Төслийн хүрээнд хамтран ажиллах гэрээтэй Багийн хөршийн 139 бүлэг (БХБ) байгуулагдаж, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Онцгой байдлын газарт бүртгүүлэн, Гамшгийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болж, түүнийгээ 2020-2021 он хүртэл шинэчлэн батлуулсан байна. Төслийн 12 сумын 53 багт иргэдийн оролцоотой Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийснээр болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх бололцоотой болсон байна.

Олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийн удирдлага, багийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх, хөршийн бүлгийн гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, зуд болон ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, сайн дурын аврагч бэлтгэх, сумын гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилалт хийх зэрэг чадавхжуулах сургалтанд 4,398 иргэн хамрагдсаны 2,232 буюу 50.7 хувь нь эмэгтэйчүүд байна.

БХБ-ийн гишүүд өөрсдийн нөөц бололцоогоор 185 өвөлжөө, хаваржаа, 19 өвс тэжээлийн агуулах барьж засварлаж, нийт 1,500 тонн хадлан, 93.5 тонн гар тэжээл бэлтгэдэг болсноор зудын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зэргээр тэдний хамтарч ажиллах хандлага дээшилсэн байна.

БХБ-ийн гишүүд бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор оготнотой тэмцэх олон төрлийн арга хэмжээ авч, 53 энгийн худаг барьж засварласнаар бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлсэн ба БХБ-ийн гишүүд түймэртэй тэмцэх гар багаж, хэрэгсэл, гамшгийн үед хэрэглэх “үүргэвч”-тэй болсноор түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийг даван туулах жижиг хэмжээний дэд бүтэц, тоног төхөөрөмж, технологи туршиж хэрэгжүүлж хээрийн түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх бололцоотой болсон байна.

Гамшгийн аюулаас сэрэмжлүүлэх дуут дохиолол суурилуулснаар 12 сумын төвийн 2,967 өрхөд эрт зарлан мэдээллийн дохио хүрдэг болж, тэдгээрийн 1,850 өрхөд барометр нийлүүлснээр цаг агаарын өөрчлөлтийг урьдчилан мэдэх боломж бүрдсэн байна.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2016 оны 176 тоот тогтоолоор батлагдсан "Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах, журам"
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан "Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"
- Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал"

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хуний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашигладаггүй, микрософтын эксел хэрэглээний программаар санхүүгийн тайлан бэлтгэдэг болно.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн үндсэн үйл ажиллагаа, дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгов.

Энэ нь төсөл хэрэгжүүлэх хугацаанд буцалтгүй тусламжаар олгогдож буй санхүүжилтийг үр ашигтай хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулаагүй байх эрсдэл үүсэх магадлалтай гэж үзсэнтэй холбоотой болно.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардал нь 4,132.0 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 82.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,891.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,609,195.9	357.4	(1,608,838.5)
Бараа материал	11,802.1	-	(11,802.1)
Үндсэн хөрөнгө	270,652.7	-	(270,652.7)
Нийт хөрөнгө	1,891,650.7	357.4	(1,891,293.3)
Хуримтлагдсан ашиг алдагдал	1,891,650.7	249,048.2	(1,642,602.5)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	(248,690.8)	(248,690.8)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,891,650.7	357.4	(1,891,293.3)

Өмнөх оны үзүүлэлтээс харахад мөнгөн хөрөнгө болон үндсэн хөрөнгөд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө нь 1,608.8 сая төгрөгөөр буурсан нь төслийн хэрэгжих хугацаа 2020 оны 4 дүгээр сарын 30-наар дуусч байгаатай холбогдуулан Азийн Хөгжлийн Банкнаас нэмэлт санхүүжилт аваагүй ба үндсэн хөрөнгө нь 270.7 сая төгрөгөөр буурсан нь мөн адил төслийн хугацаа дууссантай холбогдуулан баланс дээр бүртгэлтэй байсан хөрөнгөнүүдээ Онцгой байдлын ерөнхий газар, хүлээлгэн өгснөөс тус бууралт бүртгэгдсэн байна.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн хөрөнгийг ОБЕГ-т шилжүүлэхдээ 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 19/13 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т хүсэлт хүргүүлсэн байна. Тус хүсэлтийн дагуу ТӨБЗГ нь 2020 оны 1 дүгээр

сарын 23-ны өдөр ирүүлсэн А-1/123 албан бичгээр “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.1.1-д заасны дагуу хандив тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан бүртгэлд тусгах бөгөөд хөдлөх хөрөнгийг бүртгэхэд манай байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагагүй болно гэсэн хариу ирсний дагуу хөрөнгөнүүдийг шилжүүлсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Санхүүжилт	4,147,089.0	4,094,377.5	(52,711.5)	(1)
Хүүгийн орлого	0.0	6,190.0	6,190.0	100
Нийт дүн	4,147,089.0	4,100,567.5	(46,521.5)	(1)

/мянган төгрөг/

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн МОН-9187 дугаартай буцалтгүй тусламжийн хэлэлцээр байгуулж, АХБ-ны Ядуурлыг бууруулах Японы сангаас 3,000,000.0 ам.долларыг олгохоор зөвшөөрсөн.

Тайлант онд буцалтгүй тусламжийн орлого 4,094.4 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төлөвлөгөөнөөс 52.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

2019 онд үндсэн үйл ажиллагаанд 4,094.4 сая төгрөгийг зарцуулсан. Үүнээс 3,247.0 сая төгрөгийг машин, тоног төхөөрөмж худалдан авахад зориулж, 847.1 сая төгрөгийг бараа ажил үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 847.4 сая төгрөг зарцуулж 1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож 4 асуудлыг алдаа зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 148 мэдээллээс 144 мэдээллийг оруулсан байгаагаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 4 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн Газар болон Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан гэрээнд тус төсөл хэрэгжиж дууссаны дараа хөрөнгүүдийг данснаас хасах ба уг төсөл нь гэрээний дагуу 2020 оны 4 дүгээр сард хэрэгжиж дуусах тул дараагийн аудитаар авч үзэх гэсэн байсан.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр төсөл нь хөрөнгүүдийг данснаас хасаж зарлагын баримт үйлдсэн байгаа тул зөвлөмжийг биелүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцож тайлагнаагүй байгаатай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй байна.

3.1.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хууль хэрэгжихгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалын 21 дүгээр зүйлийн 21.1-д “Төслийн үйл ажиллагааны зардалд тухайн төсөл хэрэгжүүлэх нэгжийн тогтвортой, хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах дараах урсгал зардлууд багтана” гэсэн заалтын дагуу 21 дүгээр зүйлийн 21.1.1-д цалин, Нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр багтана гэж тусгагдсан тус журмыг мөн Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т “Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, гадаад орны дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагад ажиллаж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн” сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө гэсэн заалтыг тус тус мөрдөн ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,620,998,019.04	357,435.08
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,609,195,964.06	357,435.08
Кассанд байгаа бэлэн мөнгө	4,427,509.86	0.00
Касс арилжааны банк	4,427,509.86	0.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	1,604,768,454.20	357,435.08
Төрийн сангийн харилцах	850,000.00	0.00
Гадаад валют	1,603,918,454.20	357,435.08
Арилжааны банк дахь харилцах	1,603,918,454.20	357,435.08
БАРАА МАТЕРИАЛ	11,802,054.98	0.00
Түүхий эд материал	11,802,054.98	0.00
Бэлэн бүтээгдэхүүн	11,802,054.98	0.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	270,652,659.23	0.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	270,652,659.23	0.00
Биет хөрөнгө	270,652,659.23	0.00
Авто-тээврийн хэрэгсэл	200,907,600.00	0.00
Хуримтлагдсан элэгдэл	(33,158,339.54)	0.00
Машин тоног төхөөрөмж(компьютер)	96,063,850.00	0.00
Хуримтлагдсан элэгдэл	(30,159,921.95)	0.00
Тавилга, аж ахуйн эд хогшил	44,303,655.00	0.00
Хуримтлагдсан элэгдэл	(7,304,184.28)	0.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,891,650,678.27	357,435.08
Хуримтлагдсан үр дүн	1,891,650,678.27	249,048,223.75
Өмнөх үеийн үр дүн	742,138,554.47	1,891,650,678.27
Тайлант үеийн үр дүн	1,149,512,123.80	(1,642,602,454.52)
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	0.00	(248,690,788.67)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,891,650,678.27	357,435.08

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,646,227,578.54	2,518,377,422.93
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,646,227,578.54	2,518,377,422.93
Нийтлэг татварын бус орлого	7,068,863.03	6,190,197.67
Төсөв байгууллагын өөрийн орлого	7,068,863.03	6,190,197.67
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,068,863.03	6,190,197.67
Тусламжийн орлого	3,639,158,715.51	2,512,187,225.26
Хандив тусламж /гадаад/	3,639,158,715.51	2,512,187,225.26
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,252,068,360.16	881,119,671.18
УРСГАЛ ЗАРДАЛ	1,252,068,360.16	881,119,671.18
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,068,360.16	881,119,671.18
Үндсэн цалин	790,657,667.44	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	692,839.21	847,355,745.64
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	847,078,349.95
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	692,839.21	277,395.69
Бараа үйлчилгээний бусад зардал	460,717,853.51	33,763,925.54
Бараа үйлчилгээний бусад зардал	416,430,103.51	11,802,054.98
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,287,750.00	21,961,870.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,394,159,218.38	1,637,257,751.75
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	34,349,262.69	0.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	34,349,262.69	0.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,278,996,357.27	3,279,860,206.27
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	32,838,461.32
Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	1,278,996,357.27	3,247,021,744.95
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,149,512,123.80	(1,642,602,454.52)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,646,227,578.54	4,127,573,386.99
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,646,227,578.54	4,127,573,386.99
Нийтлэг татварын бус орлого	7,068,863.03	1,615,386,161.73
Төсөв байгууллагын өөрийн орлого	7,068,863.03	1,615,386,161.73
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,068,863.03	6,190,197.67
Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	0.00	1,609,195,964.06
Тусламжийн орлого	3,639,158,715.51	2,512,187,225.26
Хандив тусламж /гадаад/	3,639,158,715.51	2,512,187,225.26
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,207,780,610.16	847,355,745.64
УРСГАЛ ЗАРДАЛ	1,207,780,610.16	847,355,745.64
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,207,780,610.16	847,355,745.64
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	790,657,667.44	1.00
Үндсэн цалин	790,657,667.44	1.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	417,815,781.93	847,355,745.64
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	417,122,942.72	847,355,745.64
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	692,839.21	1.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,438,446,968.38	3,280,217,641.35
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,278,996,357.27	3,247,021,744.95
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,278,996,357.27	3,247,021,744.95
Дотоод эх үүсвэрээр	1,278,996,357.27	3,247,021,744.95
Тоног төхөөрөмж	1,278,996,357.27	3,247,021,744.95
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,278,996,357.27)	(3,247,021,745.95)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	34,349,262.69	(32,838,461.32)
Бусад эх үүсвэр	34,349,262.69	1.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	34,349,262.69	1.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	32,838,461.32
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	32,838,461.32
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,193,799,873.80	357,435.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	415,396,090.26	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,609,195,964.06	357,435.08

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,891,650,678.27	1,891,650,678.27
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	1,891,650,678.27	1,891,650,678.27
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	(248,690,788.67)	(248,690,788.67)
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(1,642,602,454.52)	(1,642,602,454.52)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	357,435.08	357,435.08

4.5 Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,147,089,000.00	4,094,377,490.59	-52,711,509.41	0.00
УРСГАЛ ЗАРДАЛ	847,089,000.00	847,355,745.64	0.00	0.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	847,089,000.00	847,355,745.64	0.00	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	847,089,000.00	847,355,745.64	-266,745.64	0.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	847,089,000.00	847,355,745.64	-266,745.64	0.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,300,000,000.00	3,247,021,744.95	0.00	0.00
Тоног төхөөрөмж	3,300,000,000.00	3,247,021,744.95	0.00	0.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,147,089,000.00	2,518,377,422.93	0.00	0.00
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	6,190,197.67	0.00	0.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	6,190,197.67	0.00	0.00
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	4,147,089,000.00	2,512,187,225.26	0.00	0.00
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	4,147,089,000.00	2,512,187,225.26	0.00	0.00
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.00	357,435.08	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	357,435.08	0.00	0.00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	0.00	0.00
АЖИЛЛАГСАДЫН ТОО	20.0	20.0	0.00	0.00
Удирдах ажилтан	2.0	2.0	0.00	0.00
Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0	0.00	0.00
Үйлчлэх ажилтан	0.0	0.0	0.00	0.00
Гэрээт ажилтан	2.0	2.0	0.00	0.00

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

2020.04.16	"Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/750/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Зуд болон ой хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл	Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
	Нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцож тайлагнаагүй байна.	84.9	Зөвлөмж өгсөн	Төслийн зохицуулагч, Төслийн санхүүгийн ажилтан	Д. Нямдорж С. Хажидсүрэн
	Нийт дүн	84.9			

